УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2022 оны 07 сарын 07 өдөр Дугаар А/124 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.2, 24.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Нийслэлийн 2021-2022 оны өвөлжилтийн дүн, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай" А/853 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 2.7, 4 дүгээр хэсгийн 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах улс, нийслэлийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дулаан хангамжийн төсөл арга хэмжээг эрчимжүүлэх, уялдаа холбоог хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (П.Баярхүү)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД

C:\Users\User\Desktop\УЖ 12\doc 2022\тушаал.docx

1110300747

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн
А/124 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	П.Баярхүү	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөх
	Ч.Мэндбаяр	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар /ОНӨААТҮГ/-ын дарга
	Ш.Мөнхжаргал	Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер
	Д.Энхтөр	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн дэд зохицуулагч